



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/05

Шивээговь сум

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухайн хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 30 дугаар зүйлийн 30.1, 38 дугаар зүйлийн 38.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Улаадайхан овогт Лхагважавын Баяртогтох нь Шивээговь сумын 1-р баг, 8 дугаар байрны зүүн талд байрлах “Худалдаа, нийтийн үйлчилгээний газар төв, цогцолбор”-ын зориулалттай 3150 м² газрын газар эзэмших эрхийг хэсэгчлэн шилжүүлэх хүсэлт гаргасан тул гэрээний дагуу иргэн Сэнгэ овогт Лхагважавын Ундармаад Шивээговь сумын 1-р баг, 8 дугаар байрны зүүн талд байрлах 333 м² газрыг “Худалдаа, нийтийн үйлчилгээний газар төв, цогцолбор”-ын зориулалтаар, үлдсэн 2817 м² газрыг иргэн Л.Баяртогтоход 11 жилийн хугацаагаар тус тус эзэмшүүлсүгэй.

2. Монгол Улсын Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийг дагаж мөрдөхийг газар эзэмших эрхийг шилжүүлэн авч буй иргэн (Л.Баяртогтох), (Л.Ундармаа) нарт үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрхийг шилжүүлэн авч буй иргэн Л.Баяртогтох, Л.Ундармаатай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Баярмагнай)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/143 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

42124 16